



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2018 оны 06 сарын 15 өдөр

Дугаар A-174

Улаанбаатар хот

“Журам шинэчлэн батлах тухай”

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 13 дугаар зүйл, 20¹ дугаар зүйлийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан), Тайлан бүртгэлийн газар (Т.Амарсайхан), Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул)-нд тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Д.Аюуш)-т даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 497 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРСАЙХАН

14 1102

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны
6.дугаар сарын 15^{тийн} 2018 дугаар
тушаалын хавсралт

МОНГОЛБАНКНААС БАНКИНД ОЛГОХ БАРЬЦААТ ЗЭЭЛИЙН ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 20¹ дүгээр зүйлд заасны дагуу Монголбанк банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор банкинд барьцаат зээл олгох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:
 - 1.2.1. “Барьцаат зээл” гэж банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор энэ журмын 1.2.2-т заасан барьцаа хөрөнгийг барьцаалан банкинд олгох зээлийг;
 - 1.2.2. “Барьцаа хөрөнгө” гэж Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 20¹.3-т заасан жагсаалтад багтсан, зээлдэгч банкнаас зээлийн барьцаанд ирүүлсэн активыг хэлнэ.

Хоёр. БАНКИНД БАРЬЦААТ ЗЭЭЛ ОЛГОХ ҮНДЭСЛЭЛ, ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- 2.1 Монголбанк барьцаат зээлийг дараах нөхцөлийг хангасан банкинд олгож болно.
Үүнд:
 - 2.1.1 Төлбөрийн чадвартай боловч төлбөр түргэн гүйцэтгэх чадварт түр хугацааны хүндрэл үссэн;
 - 2.1.2 Өөрийн үйл ажиллагааны үр дүнд энэ журмын 2.1.1-д заасан хүндрэлээс гарч, зээлийг хугацаанд нь эргүүлэн төлөх боломжтой;
 - 2.1.3 Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах бусад арга хэмжээг хангалттай авсан гэж Монголбанк үзсэн.
- 2.2 Барьцаат зээлийг 90 хоног хүртэл хугацаатай олгож болох бөгөөд банкны хүсэлтийг үндэслэн Монголбанкны шийдвэрээр зээлийн хугацааг 90 хоногоос дэшгүй хугацаагаар нэг удаа сунгаж болно.
- 2.3 Банк барьцаат зээлийн хугацааг сунгуулах хүсэлтийг зээлийн хугацаа дуусахаас ажлын 10 хоногийн өмнө энэхүү журмын 2.5-д заасан бичиг баримтуудын хамт Монголбанкинд ирүүлнэ.
- 2.4 Барьцаат зээлийн хүү нь Монголбанкны санхүүжилтийн байнгын хэрэгслийн хамгийн өндөр хүүтэй зээлийн хүү дээр 5 (таван) нэгж хувийг нэмсэнтэй тэнцүү байна.
- 2.5 Банк барьцаат зээл авахдаа доорх бичиг баримтуудын хамт энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу бэлтгэж, Монголбанкны зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газарт ирүүлнэ:
 - 2.5.1 Барьцаат зээл хүссэн албан бичиг;
 - 2.5.2 Барьцаа хөрөнгөд санал болгож байгаа активын жагсаалт;
 - 2.5.3 Ирэх 6 сарын хугацааны мөнгөн хөрөнгийн орох, гарах урсгалын таамаглал.
- 2.6 Монголбанк барьцаат зээл олгох шийдвэр гаргахад шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээллийг банкнаас шаардаж болно.
- 2.7 Монголбанкны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж Монголбанкны хүлээн зөвшөөрөх актив хөрөнгийн жагсаалтын төслийг боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгч батална.
- 2.8 Банкнаас ирүүлсэн барьцаа хөрөнгө болох актив нь барьцаат зээлийн төлөгдөх

хугацаанаас хойш хамгийн багадаа 90 хоногийн дараа банкинд эргэн төлөгдөхөөр байна.

- 2.9 Эрсдэлийн хямдруулалт тооцсоны дараах барьцаа хөрөнгийн үнэлгээ нь зээлийн нийт дунгээс багагүй байна.

Гурав. БАРЬЦААТ ЗЭЭЛ ОЛГОХ ЗАРЧИМ

- 3.1 Монголбанкны хяналт шалгалтын үйл ажиллагаа хариуцсан газар хүсэлт гаргасан банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн мэдээлэл болон төлбөрийн чадварын дүгнэлт (төлбөрийн чадварын өнөөгийн байдал болон ирэх 3 сарын төлвийг хамарсан байна)-ийг гаргана.
- 3.2 Банкны санал болгосон барьцаа хөрөнгийн чанарыг шалгах үйл ажиллагааг хяналт шалгалт үйл ажиллагаа хариуцсан газар гүйцэтгэнэ.
- 3.3 Барьцаа хөрөнгийн үнэлгээг эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжийн боловсруулсан аргачлалын дагуу, зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар, эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж хамтран гүйцэтгэнэ.
- 3.4 Монголбанкны зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар болон хяналт шалгалтын үйл ажиллагаа хариуцсан газар энэ журмын 2.5-д заасан хүсэлтийг, 3.1-д заасан дүгнэлт болон 3.2, 3.3-д заасан барьцаа хөрөнгийн үнэлгээний хамт Банкны хяналт шалгалтын хороо (щашид “хороо” гэх)-нд хүргүүлж, хороо нь ажлын 3 өдрийн дотор банкинд барьцаат зээл олгох эсэх талаар Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөмж гаргана.
- 3.5 Монголбанкны Ерөнхийлөгч нь хорооны зөвлөмж, банкнаас ирүүлсэн барьцаа хөрөнгийн хүрэлцээт байдлыг харгалзан банкны хүсэлтийг шийдвэрлэж, энэхүү журмын 2 дугаар хавсралтад тусгасан маягтын дагуу шийдвэрийг баталгаажуулна.
- 3.6 Банкны барьцаа хөрөнгийг зээл эргэн төлөгдөх өдөр хүртэл тусгаарлах ажлыг Монголбанкны тайлан бүртгэл, хяналт шалгалт болон зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газрууд хамтран гүйцэтгэнэ.
- 3.7 Монголбанк банкинд барьцаат зээл олгоходоо зээлдэгч банктай энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу Барьцаат зээлийн гэрээ болон Барьцааны гэрээ байгуулна.
- 3.8 Энэ журмын 3.7 дахь заалтыг зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар хэрэгжүүлнэ.
- 3.9 Монголбанк банкны төлбөрийн чадварын байдал, барьцаа хөрөнгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан тухайн банкинд барьцаат зээл олгохоос татгалзаж болно.
- 3.10 Энэ журмын 3.7-д зааснаар гэрээ байгуулснаас хойш ажлын 1 өдрийн дотор зээлдэгч банк нь зээлийн төлбөрийн нийт дүн бүхий, зээлийн хугацаанаас багагүй хугацаатай энгийн векселийг бичиж Монголбанкинд ирүүлнэ.
- 3.11 Энэ журмын 3.10-т заасан хугацаанд банк векселийг ирүүлээгүй бол Монголбанк гэрээнээс татгалзах арга хэмжээ авна.

Дөрөв. БАРЬЦААТ ЗЭЭЛ АВСАН БАНКИНД ТАВИХ ШААРДЛАГА

- 4.1 Зээлдэгч банк нь Монголбанкинд барьцаа болгосон активыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг барьцаат зээлийн хугацаанд гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр шилжүүлэхгүй, шаардах эрх үүсгэхгүй, эрхийн зөрчилгүй, аливаа доголдолоос ангид байлгах үүрэгтэй.
- 4.2 Барьцаат зээлийн гэрээ байгуулагдснаас хойш барьцааг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу үүссэнийг гэрчилсэн, баталгаажуулсныг нотлох шийдвэр (банкны эрх бүхий этгээдийн шийдвэр), баримт бичгийн хамт ажлын 2 өдрийн дотор Монголбанкинд ирүүлнэ.
- 4.3 Зээлдэгч банк нь барьцаат зээлийн хугацаанд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл,

- гаргасан баталгаа, батлан даалт, аккредитивийн гэрээ, хэлцэл болон тэдгээртэй адилтгах авлагын үлдэгдлийг нэмэгдүүлэхгүй. Үүнд: Засгийн газраас хэрэгжүүлж буй төслийн зээл, гадаадын засгийн газар, банк санхүүгийн байгууллагаас хэрэгжүүлж буй төслийн зээл хамаарахгүй.
- 4.4 Зээлдэгч банк зээлийн хугацаанд 2 долоо хоног тутам олгосон зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн ангиллын мэдээг энэхүү журмын 4 дугээр хавсралтын дагуу бэлтгэж, 2 долоо хоног дууссанаас хойш дараагийн долоо хоногийн эхний ажлын өдөрт багтаан Монголбанкинд албан бичгээр ирүүлнэ.
- 4.5 Барьцаат зээлийн барьцаанд ирүүлсэн актив нь хугацаанаасаа өмнө эргэн төлөгдсөн, зээлийн ангилал буурсан тохиолдолд зээлдэгч банк нэн даруй Монголбанкинд мэдэгдэнэ.
- 4.6 Энэхүү журмын 4.5-т заасны дагуу барьцаа хөрөнгө хугацаанаасаа өмнө эргэн төлөгдсөн, зээлийн ангилал буурсан тохиолдолд Монголбанкны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж, зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар хамтран банкны нийт барьцаа хөрөнгийг дахин үнэлнэ.
- 4.7 Барьцаа хөрөнгийн дахин үнэлгээ нь эрсдэлийн хямдруулалт тооцсоноор зээлийн дүнгээс буурсан тохиолдолд Монголбанк зээлдэгч банкинд мэдэгдэж, зээлдэгч банк ажлын 3 өдрийн дотор барьцаа хөрөнгийн хэмжээг анхны барьцаа хөрөнгийн үнэлгээний хэмжээнд хүргэж нэмэгдүүлнэ.
- 4.8 Барьцаат зээлийн үлдэгдэлтэй банкны Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг хуваарилах бол энэ тухай саналаа Монголбанкинд албан бичгээр ирүүлж, зөвшөөрөл авах шаардлагатай.

Тав. БАРЬЦААТ ЗЭЭЛИЙГ БУЦААН ТӨЛҮҮЛЭХ

- 5.1 Зээлдэгч банк энэхүү журам болон гэрээний заалтыг биелүүлээгүй тохиолдолд Монголбанк барьцаат зээлийн гэрээг хугацаанаас нь өмнө дангаар цуцалж, зээлийг төлүүлэх арга хэмжээ авна.
- 5.2 Зээл бүрэн төлөгдөж дуусахад барьцааны эрхийг дуусгавар болгосон тухай банкинд мэдэгдэж, зохих арга хэмжээг авна.
- 5.3 Барьцаат зээл буцаан төлөгдөх өдөр зээлдэгч банк Монголбанкин дахь харилцах дансандаа зээлийн төлбөрийг төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний мөнгөн хөрөнгөгүй тохиолдолд зээлийн үлдэгдлийг Монголбанкны активыг ангилах талаарх журмын дагуу хугацаа хэтэрсэн зээлийн дансанд шилжүүлэн бүртгэж, зээлийн үндсэн хүүгийн 20 хувьтай тэнцүү нэмэгдүүлсэн хүү тооцно.
- 5.4 Монголбанк барьцаат зээлийн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлтэй банкинд шинээр нэмж зээл олгохыг зогсоож, банк хоорондын гүйлгээгээр тухайн банкны дансанд орлогоор эхлээд үндсэн зээлийн төлбөрийг, дараа нь үндсэн зээлийн хүү болон нэмэгдүүлсэн хүүний төлбөрийг төлүүлнэ.
- 5.5 Барьцаат зээлийн төлбөрийн хугацаанаас хойш 30 хоногт зээлийн үлдэгдэл төлөгдөөгүй бол хяналт шалгалт хариуцсан газар барьцаа хөрөнгөөр төлбөрийг хангуулах эсэх санал боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж шийдвэрлүүлнэ.
- 5.6 Зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар энэ журмын 5.5-д заасан шийдвэрийг үндэслэн холбогдох арга хэмжээг авна.

Зургаа. ХЯНАЛТ

- 6.1 Монголбанкны зах зээл болон хяналт шалгалтын үйл ажиллагаа хариуцсан газрууд барьцаат зээл авсан банкинд тогтмол хяналт тавьж ажиллана.
- 6.2 Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж хяналт тавьж, хөрөнгийн үнэлгээ өөрчлөгдсөн тохиолдолд зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газарт мэдэгдэнэ.
- 6.3 Монголбанкнаас олгосон барьцаат зээл хугацаандаа төлөгдөөгүйгээс хугацаа хэтэрсэн, эсхүл чанаргүй активт шилжсэн тохиолдолд Монголбанкны активыг ангилах, болзошгүй алдагдлын нөөцийн сан байгуулах, зарцуулах журмын дагуу ангилж, нөөцийн сан байгуулна.
- 6.4 Монголбанкнаас олгосон барьцаат зээлийг Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу бүртгэж, бүртгэлээр тавих хяналтыг Монголбанкны тайлан бүртгэл хариуцсан газар гүйцэтгэнэ.
- 6.5 Барьцаат зээлийн хугацаанд барьцаа хөрөнгийг жагсаалтад заагаагүй хөрөнгөөр солих, чанарыг бууруулах, хэлцлийн төрлийг өөрчлөх санал, аливаа шийдвэр гаргахгүй.
- 6.6 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

_____oOo_____

(Барьцаат зээл хүссэн албан
бичгийн агуулга)

“Монголбанкнаас банкинд олгох
барьцаат
зээлийн журам”-ын 1 дүгээр
хавсралт

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ... ТАНАА

Барьцаат зээл хүсэх тухай

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлд
орсон шалтгаан:

Зээлийн хэмжээ болон хугацаа:

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах
бусад боломжит арга хэмжээг авсан байдал:

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлийг
даван туулах төлөвлөгөө:

Барьцаат зээлийг эргүүлэн төлөх эх үүсвэр:

Банкны өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтүүд
/сүүлийн байдлаар/:

(Барьцаа хөрөнгийн эсагсаалт)

“Монголбанкнаас банкннд олгох барьцаат
зээлийн журам”-ын 1 дүтээр хавсралт
(Ургэлжлэл)

**... БАНКНААС МОНГОЛБАНКНИД ИРҮҮЛЭХ
БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Барьцааны зүйлийн нэр (...ХХК, ЗЭЭЛДЭЧИЙН НЭР ГЭХ МЭТ)	Барьцаа болох активын төрөл (ТБҮЦ/ЗГҮЦ/ЗЭЭЛГЭХ МЭТ)	Регистр, бүртгэлийн дугаар	Зээлийн гэрээний дугаар	Активын ангилаал, чанар	Барьцаа хөрөнгийн байршил	Барьцааны дүн	Эргэн төлөгдөх хугацаа	Эрсдэлийн хямдруулалт тооцсон дүн
1.									
2.									
3.									
4.									
5.									
6.									
Нийт дүн									

(Ирэх б сарын хугацааны мөнгөн
хөрөнгийн орох, гарах урсгалын
маамаглал)

“Монголбанкнаас банкинд олгох барьгаат
зээлийн журам”-бын 1 дүгээр хавсралт
(Ургэлжлэл)

... БАНКНЫ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ОРОХ, ГАРАХ
УРСГАЛЬН ТАЛАМАГЛАЛ

	... оны ... cap	Тайлбар ¹						
Бэлэн мөнгөний эхний үлдэгдэл								
1. Орох мөнгөн урсгал								
1.1. Хариццах								
1.2. Хадгаламж								
1.3. Зээл, зээлийн хувьний эргэн төлөлт								
1.3.1. ...								
1.4. Банк, санхүүгийн байгууллагаас татах эх үүсвэр								
1.4.1. ...								
1.5. Бусад эх үүсвэр								
1.5.1. ...								
2. Гарах мөнгөн урсгал								
2.1. Хариццах								
2.2. Хадгаламж								
2.3. Зээл								
2.3.1. ...								
2.4. Банк, санхүүгийн байгууллагаас татах эх үүсвэрийн эргэн төлөлт								
2.4.1. ...								
2.5. Бусад эх үүсвэр								
2.5.1. ...								

¹ Том дунтэй мөнгөн урсталаудын тайлбар, нэмэлт мэдээлэл байна.

3. Цэвэр мөнгөн урсгал (1-2)				
Бэлэн мөнгөний эдсийн Улдэгдэл				
Түргэн борлогдох активын хэмжээ				
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа				
5.Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсн активын харьцаа				



“Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам”-ын 2 дугаар хавсралт

БАНКИНД БАРЬЦААТ ЗЭЭЛ ОЛГОХ/ЗЭЭЛИЙН ХУГАЦАА СУНГАХ ШИЙДВЭР

20... оны ... сарын өдөр

Банкны хяналт шалгалтын хорооны зөвлөмж /хурлын протоколыг хавсаргах/:

Монголбанкны Ерөнхийлөгч / /

“Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам”-ын 3 дугаар хавсралт

БАРЬЦААТ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

20... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нэг талаас Монголбанк (цаашид “Зээлдүүлэгч” гэх), нөгөө талаас банк (цаашид “Зээлдэгч” гэх)-нд Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 20¹ дүгээр зүйл, Монголбанкны Ерөнхийлөгчийн ... оны ... дугаар тушаалаар батлагдсан “Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам”-ыг тус тус үндэслэн зээл олгохоор харилцан тохиорлцож энэхүү гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээний зорилго нь Иргэний хууль, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль болон “Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам”-д нийцүүлэн зээл олгох, түүний хүүгийн хувь хэмжээ, хугацааг тогтоох, эргэн төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.3 Зээлдүүлэгч нь зээлдэгчид дараах нөхцлөөр барьцаат зээл олгоно:

Зээлийн дүн: тэрбум төгрөг

Зээлийн зориулалт: Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах

Зээлийн хүүгийн хувь хэмжээ: хувь (жилийн, тогтмол)

Зээлийн хугацаа: хоног

Зээлийн барьцаа: Барьцааны гэрээний 1 дүгээр хавсралт

Хоёр. Зээлдүүлэгчийн эрх, үүрэг

2.1 Зээлдүүлэгч нь дор дурьдсан эрх, үүрэгтэй:

2.1.1 Энэхүү гэрээний 1.3-т заасан нөхцлийн дагуу Зээлдэгчид барьцаат зээл олгох.

2.1.2 Энэхүү гэрээний 1 дүгээр хавсралтаар тогтоосон хуваарийн дагуу зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг эргүүлэн төлүүлэх.

2.1.3 Зээлдэгч тогтоосон хуваарийн дагуу зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг гүйцэтгээгүй тохиолдолд Зээлдэгчийн Зээлдүүлэгчид байршиж буй төгрөгийн болон гадаад валютын харилцах данснаас үл маргах журмаар буцаан төлүүлэх. Гадаад валютын данснаас зээлийг төлүүлэх тохиолдолд тухайн өдрийн Монголбанкны албан ханшийг хэрэглэх.

2.1.4 Зээлдэгч тогтоосон хуваарийн дагуу зээлийн төлбөрийг гүйцэтгээгүй тохиолдолд уг зээлийг хугацаа хэтэрсэн зээлийн дансанд шилжүүлэн бүртгэж, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд үндсэн хүүг 20 хувиар нэмэгдүүлж хүү тооцох.

- 2.1.5 Барьцаат зээл хугацаандаа төлөгдөхгүй 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл Зээлдүүлэгч нь Зээлдэгчийн барьцаа хөрөнгөөр зээлийг эргүүлэн төлүүлэх эрхтэй.
- 2.1.6 Зээлдэгчийн зээлийн ашиглалт болон эргэн төлөлтийн талаар тайлан, мэдээ гаргуулан авах, байнгын хяналт тавих.

Гурав. Зээлдэгчийн эрх, үүрэг

- 3.1 Зээлдэгч нь дор дурьдсан эрх үүрэгтэй:
- 3.1.1 Зээлийн эх үүсвэрийг энэхүү гэрээний 1.3-т заасан зориулалтаар ашиглах.
- 3.1.2 Зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Зээлдүүлэгчид буцаан төлөхийг баталж бичсэн энгийн векселийг гэрээ байгуулснаас хойш ажлын 1 өдрийн дотор Зээлдүүлэгчид ирүүлэх.
- 3.1.3 “Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам”-ын 2.5.2-т заасан өөрийн тэнцэлд бүртгэлтэй байгаа активыг Зээлдүүлэгчээс авч буй зээлийн барьцаа болгох.
- 3.1.4 Зээлийн барьцаанд ирүүлсэн актив нь хугацаанаасаа өмнө эргэн төлөгдсөн, зээлийн ангилал буурсан тохиолдолд тэр даруй Зээлдүүлэгчид мэдэгдэнэ.
- 3.1.5 Барьцаа хөрөнгийн үнэлгээ нь эрсдэлийн хямдруулалт тооцсоноор зээлийн дүнгээс буурсан тохиолдолд Зээлдүүлэгчийн мэдэгдлийн дагуу ажлын 3 өдрийн дотор барьцаа хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх.
- 3.1.6 Зээлдүүлэгчээс авсан зээлийг хугацаанд нь хүүгийн хамт эргүүлэн төлөх үүрэгтэй бөгөөд зээл эргэн төлөгдөх өдөр Зээлдүүлэгч дэх харилцах дансандaa зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулах.
- 3.1.7 Барьцаа хөрөнгийн ~~ө~~ болон шаардах эрхийг бүхэлд нь, эсвэл зарим хэсгийг гуравдагч отгөөдд аливаа хэлбэрээр шилжүүлэхгүй, шаардах эрх үүсгэхгүй, эрхийн зөрчилгүй, аливаа доголдолоос ангид байлгах.
- 3.1.8 Зээлийн хугацаанд 2 долоо хоног бүрийн зээлийн өрийн үлдэгдлийн мэдээг 2 долоо хоног дууссанаас хойш дараагийн долоо хоногийн эхний ажлын өдөрт багтаан Монголбанкинд албан бичгээр ирүүлж байх.
- 3.1.9 Барьцаат зээлийн үлдэгдэлтэй банкны Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг хуваарилаж бол эсэ тухай сапалаа Монголбанкинд албан бичгээр ирүүлж, зөвшөөрөл авах.

Дөрөв. Бусад



- 4.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Гэрээг хоёр хувь үйлдэн талууд өөрсдийн хувира хадгалах бөгөөд хувь тус бүр нь хуулийн адил хүчинтэй байна.
- 4.2 Энэхүү гэрээ нь Зээлдэгчийн гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.
- 4.3 Энэхүү гэрээнд талууд харилцан тохиролцож нэмэлт заалт оруулж болно.

- 4.4 Энэхүү гэрээ нь Зээлдэгчийн эрх залгамжлагчид нэгэн адил үйлчилнэ.
- 4.5 Зээлдэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хохирлыг барьцааны зүйлээс төлүүлэхдээ Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг баримтална.
- 4.6 Энэхүү гэрээний талаархи маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэж эс чадвал Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗЭЭЛДҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :

МОНГОЛБАНКНЫ НӨӨЦИЙН
УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

ЗЭЭЛДЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

... БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

МОНГОЛБАНКНЫ ТАЙЛАН
БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

... БАНКНЫ ... ГАЗРЫН ЗАХИРАЛ

МОНГОЛБАНК, ... БАНКНЫ ХООРОНД ХИЙСЭН БАРЫЦААТ ЗЭЭЛ БУЦААН ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

20... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Нэг. Төлбөрийн хуваарь

1.1 ... оны ... дугаар сарын ...-ны өдрийн “Барьцаат зээлийн гэрээ”-г үндэслэн дараах төлбөрийн хуваарийг байгуулав.

Зээл олгох өдөр: .../.../...

Төлбөр хийгдэх хугацаа	Хүү тооцох үндсэн зээлийн үлдэгдэл	Хүү тооцох хоног	Хүүгийн төлбөр	Зээлийн үндсэн төлбөр	Нийт төлбөр
.../.../...					
.../.../...					
.../.../...					
Нийт					

Хоёр. Бусад

2.1 Зээлийн хүүгийн төлбөрийг Монголбанк сар бүр хуримтлуулан тооцож, сар бүрийн эцсийн өдөр банкны Монголбанкин дахь харилцах данснаас суутган авна.

2.2 Энэхүү хуваарь нь ... оны ... дугаар сарын ...-ний өдөр байгуулсан “Барьцаат зээлийн гэрээ”-ний салшгүй хэсэг бөгөөд уг гэрээний хамт хучин төгөллөр байна.

ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ БАЙГУУЛСАН

ЗЭЭЛДҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :

ЗЭЭЛЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

МОНГОЛБАНКНЫ НӨӨЦИЙН УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

... БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

МОНГОЛБАНКНЫ ТАЙЛАН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

... БАНКНЫ ... ГАЗРЫН ЗАХИРАЛ

“Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн
журам”-ын 3 дугаар хавсралт (үргэлжлэл)

БАРЬЦААНЫ ГЭРЭЭ

20... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү Барьцааны гэрээг нэг талаас Монголбанк (цаашид “Барьцаалагч” гэх) нөгөө талаас ... банк (цаашид “Барьцаалуулагч” гэх) Монголбанкны Ерөнхийлөгчийн ... оны ... дугаар тушаалаар баталсан “Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам”, Иргэний Хуулийн 153-181 дүгээр зүйлийг үндэслэн дор дурдсан нөхцөлтэйгээр харилцан тохиролцож байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээ нь Монголбанк, ... банкны хооронд ... оны ... дүгээр сарын ...-ний өдөр байгуулсан ... дугаар “Барьцаат зээлийн гэрээ”-ний үргийн биелэлтийг хангахтай холбогдуулан барьцаалах хөрөнгийг тогтоох, тэдгээрийн үнэлгээ, чанарыг тодорхойлох болон барьцааны гэрээ хэрэгжих үндэслэл бүрдсэн нөхцөлд барьцаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Барьцааны нөхцөл

- 2.1 Барьцааны зүйл нь Монголбанкны Ерөнхийлөгчийн ... оны ... дугаар тушаалаар баталсан “Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам”-ын 2.5.2-д заасны дагуу Барьцаалуулагчийн ирүүлсэн Барьцаалагчийн хулээн зөвшөөрсөн актив байна.
- 2.2 Барьцаалуулагч барьцаа хөрөнгийн талаарх мэдээллийг энэхүү Барьцааны гэрээний 1 дүгээр хавсралтын дагуу Барьцаалагчид ирүүлнэ.
- 2.3 Барьцаалагч барьцааны зүйлээс хамаарч тухайн барьцаа хөрөнгөтэй холбоотой бусад мэдээллийг Барьцаалуулагчаас шаардаж болно.
- 2.4 Барьцаалуулагчийн ирүүлсэн барьцаа хөрөнгө болох активууд нь барьцаат зээлийп тологдох хугацаанаас хойш хамгийн багадаа 90 хоногийн дараа барьцаалуулагчид эргэн төлөгдхөөр байна.
- 2.5 Барьцаалсан хөрөнгийг өмчлөх эрх өөр этгээдэд аливаа хэлбэрээр шилжсэн тохиолдолд барьцааны эрх хүчин төгөлдөр хэвээр үлдэх бөгөөд барьцаалсан хөрөнгийн талаар энэ гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө болон хойно хийсэн аливаа гэрээ, хэлцэл барьцаалагчийн хувьд үл хамаарах ба хүчин төгөлдөр бус гэж тооцогдоно.

Гурав. Барьцаалагчийн эрх, үүрэг

- 3.1 Барьцаалуулагчаас зээлийн барьцаа болгосон активыг магадлан шалгаж хүлээн авах.
- 3.2 Шаардлагатай тохиолдолд барьцаалсан эд хөрөнгийн талаар давхар эрх эдлэх гуравдагч этгээд байгаа эсэхийг холбогдох лавлагааг гаргуулж магадлах.
- 3.3 Барьцаат зээл олгосон хугацаанд Монголбанкнаас барьцаат зээл олгоход барьцаалж болох хөрөнгийн жагсаалтыг шинэчлэн баталсан тохиолдолд энэ талаар тухай бүр барьцаалуулагчид мэдэгдэх.

3.4 Барьцаа хөрөнгө хугацаанаасаа өмнө эргэн төлөгдсөн, зээлийн ангилал буурч барьцаа хөрөнгийн үнэлгээ нь эрсдэлийн хямдруулалт тооцсоноор зээлийн дүнгээс буурсан тохиолдолд Барьцаалулагчид мэдэгдэж, ажлын 3 өдрийн дотор барьцаа хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхийг шаардах эхтэй.

3.5 Барьцаат зээл 30 хоногоос дээш хугацаагаар хугацаа хэтэрвэл барьцааны зүйлэс зээлийг эргүүлэн төлүүлэх эрхтэй.

Дөрөв. Барьцаалулагчийн эрх, үүрэг

4.1 “Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам”-ын 2.7 дахь заалтад нийцсэн активыг барьцаа болгох.

4.2 Эзэмших эрхийн зөрчилгүй, биет байдлын доголдолгүй хөрөнгийг барьцаалах.

4.3 Барьцаат зээлийн гэрээ дуусгавар болох хүртэл хугацаанд барьцааны хөрөнгө болон түүний эзэмших эрхтэй холбогдсон аливаа бичиг баримтын эх хувийг Барьцаалагчид хадгалуулах.

4.4 Барьцааны хөрөнгийн эрхийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр шилжүүлэхгүй, шаардах эрх үүсгэхгүй, эрхийн зөрчилгүй, аливаа доголдолоос ангид байлгах.

4.5 Барьцаа хөрөнгийн үнэлгээ буурч, зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангахад хүрэлцэхгүй болсон тохиолдолд Барьцаалагчийн мэдэгдлийн дагуу ажлын 3 хоногийн дотор барьцаа хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх.

4.6 Барьцаа хөрөнгө нь банкны зээл байх тохиолдолд Барьцаалулагч нь уг зээлийн эргэн төлөлтийн тусгай дансыг шинээр нээж, зээлийн хугацаанд хуваарийн дагуу төлөгдсөн болон хугацаанаасаа өмнө эргэн төлөгдсөн зээлийн төлбөрийг тухайн дансанд хуримтлуулж, уг дансыг зээлийн барьцаа болгох.

4.7 Барьцаалагчаас авсан зээлийн үндсэн өр, хүү, нэмэгдүүлсэн хүүг бүрэн төлөх хүртэл хугацаанд барьцаа хөрөнгийн чанар, үнэлгээг бууруулахгүй байх.

4.8 Барьцаа хөрөнгийн чанар, үнэлгээ буурсан тохиолдолд чанартай барьцаагаар бүрэн солих.

4.9 Зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн тохиолдолд энэхүү гэрээний 2.1-д заасан барьцаа хөрөнгийг барьцааны бүртгэлээс чөлөөлөхийг Барьцаалагчаас шаардах.

Тав. Бусад

5.1 Энэхүү гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгч гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болох ба талуудын хооронд байгуулсан зээлийн гэрээний аливаа үүргийг бүрэн биелүүлж дууссанаар дуусгавар болно.

5.2 Хэрэв барьцааны зүйлийн талаар гуравдагч этгээдээс маргаан гарсан тохиолдолд Барьцаалагч гуравдагч этгээдээс давуу эрхтэй байна.

5.3 Энэхүү гэрээнд заасан барьцаагаар хангагдаж буй үүргийн агуулга, хэмжээ, үнэ, биелүүлэх хугацаа нь Барьцаат зээлийн гэрээгээр зохицуулагдана. Барьцаагаар хангагдах үүргийн хэмжээнд тухайн үүргээс гадна түүнийг биелүүлээгүйн улмаас үүсэх бүх хохирлыг оруулан тооцно.

- 5.4 Энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргийн талаар гарсан маргааныг хоёр тал шийдвэрлэхийн тулд бүхий л арга хэмжээг авна. Хэрэв тэрхүү арга хэмжээ нь зохих үр дүнд хүрээгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 5.5 Энэхүү гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 5.6 Энэхүү гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол улсад дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

БАРЫЦААЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

МОНГОЛБАНКНЫ НӨӨЦИЙН
УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

БАРЫЦААЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

... БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

МОНГОЛБАНКНЫ ТАЙЛАН
БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

... БАНКНЫ ... ГАЗРЫН ЗАХИРАЛ

... БАНКНААС МОНГОЛБАНКИНД ИРҮҮЛСЭН БАРЬЦАА
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

20... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Нэг. Барьцаа хөрөнгө

1.1 Монголбанк, ... банкны хооронд хийсэн ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн “Барьцааны гэрээ”-г үндэслэн дараах активуудыг Монголбанкнаас олгосон зээлийн барьцаа болгов.

Д/ д	Барьцааны зүйлийн нэр (... ХХК, зээлдэгчийн нэр гэх мэт)	Барьцаа болох активын төрөл (ТБҮЦ/ЗГҮЦ/Зээлгэх мэт)	Регистр, бүртгэлийн дугаар	Зээлийн гэрээний дугаар	Активын ангилаал, чанар	Барьцаа хөрөнгийн байршил	Барьцаа нарын дүн	Эргэн төлөгдөх хугацаа	Эрсдэлийн хямдруулалт тооцсон дүн
1.									
2.									
3.									
4.									
5.									
6.									
Нийт дүн									

Хоёр. Бусад

2.1 Энэхүү барьцаа хөрөнгийн жагсаалт нь ... оны ... дүгээр сарын ...-ны өдөр байгуулсан “Барьцааны гэрээ”-ний салшгүй хэсэг бөгөөд уг гэрээний хамт хүчин төгөлдөр байна.

БАРЬЦААЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

МОНГОЛБАНКНЫ НӨӨЦИЙН
УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

БАРЬЦААЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

... БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....
МОНГОЛБАНКНЫ ТАЙЛАН
БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

.....
... БАНКНЫ ... ГАЗРЫН ЗАХИРАЛ

“Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

... БАНКНЫ ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЛИЙН МЭДЭЭ

... оны ... сарын ... өдөр байгуулсан ... дугаартай Барьцаат зээлийн гэрээний 3.1.8 дахь заалт: